



**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД БОЛОН НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХООРОНД
ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025.07.08

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй:

Засгийн газрын гишүүн Зам, тээврийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг баримталан ажиллав.

Хоёр. Танилцуулга:

Засгийн газрын гишүүн Зам, тээврийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 5 зорилтын 19 арга хэмжээ тусгагдсанаас бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлтэй 5, 90 хувийн биелэлттэй 1, 70 хувийн биелэлттэй 5, 50 хувийн биелэлттэй 5, 30 хувийн биелэлттэй 3 арга хэмжээний дундаж үнэлгээ 67.4 хувь байна. “Гэрээ”-ний хэрэгжилтийг зорилт тус бүрээр доорх хүснэгтээр үзүүлэв.

/Хүснэгт 1/

№	Зорилт	Нийт	Үнэлгээ /хувиар/						Хугацаа болоогүй	Дундаж үнэлгээ
			100	90	70	50	30	0		
1	1-р зорилт	4	2	-	1	-	1	-	-	75.0
2	2-р зорилт	8	-	-	4	3	1	-	-	57.5
3	3-р зорилт	1	-	-	-	1	-	-	-	50.0
4	4-р зорилт	3	2	-	-	-	1	-	-	76.6
5	5-р зорилт	3	1	1	-	1	-	-	-	80.0
Нийт		19	5	1	5	5	3	-	-	67.4



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

2025 оны хагас жилийн байдлаар “Гэрээ”-нд тусгагдсан 19 арга хэмжээнээс цаашид эрчимжүүлэн ажиллах шаардлагатай “30-50” хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ байна. Үүнд:

/Хүснэгт 2/

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/	Хариуцсан нэгж
1	3. Тусгай замын автобус (BRT)-ны сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлнэ	30	АТБЗГ
2	7. Улаанбаатар хотын "Шинэ их тойруу" хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ байгуулах	30	АТБЗГ
3	9. Шинэ тойрог зам төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Туул голын дагуух хурдны замыг барина	50	АЗБЗГ
4	10. Шинэ тойрог зам төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Баянзүрхийн гүүр хүртэлх авто замыг барина	50	АЗБЗГ
5	11. Унадаг дугуй болон явган зорчигчдод ээлтэй дэд бүтцийг нэмэгдүүлнэ	50	АЗБЗГ
6	13. Гудамж замын уулзваруудын болон тээврийн ухаалаг систем нэвтрүүлэхэд шаардлагатай программ хангамж, техник тоног төхөөрөмжийн худалдан авалт хийж, 168 гэрэл дохионы ухаалаг контроллер суурилуулна	30	АТБЗГ
7	15. Аюултай ачаа тээвэрлэх автомашинуудад байршил тогтоогч GPS суурилуулна.	30	АТБЗГ
8	17. Авто замын сүлжээний арчлалт, урсгал засварын ажлын төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно	30	АЗБЗГ

“Гэрээ”-г хамтран хэрэгжүүлэхээр давхардсан тоогоор 38 арга хэмжээг авч үзэхэд бүрэн хэрэгжсэн 13, 70 хувийн 9, 50 хувийн 9, удаашралтай буюу 30 хувийн 7 арга хэмжээний хэрэгжилт **68.2** хувь байна.

Эдгээр нэгж, байгууллагуудын хариуцсан арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээг доорх хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 3/

№	Хариуцах газар	Нийт	Үнэлгээ /хувиар/						Хугацаа болоогүй	Үнэлгээ
			100	90	70	50	30	0		
1	Нийслэл	18	6	-	4	5	3	-	-	67.8
2	АЗБЗГ	10	1	-	4	4	1	-	-	61.0
3	АТБЗГ	7	5	-	-	-	2	-	-	80.0
4	ТЗДТБЗГ	3	1	-	1	-	1	-	-	66.7
Нийт		38	13	0	-	9	7	-	-	68.2



Гурав. Үнэлэлт, дүгнэлт:

3.1. Засгийн газрын гишүүн Зам, тээврийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээг 2025 оны эхний улиралд шинэчлэн байгуулсан байна. 2025 оны хагас жилийн байдлаар гэрээнд туссан 5 зорилтын 19 арга хэмжээний дундаж үнэлгээ 67.4 хувьтай.

3.2. Засгийн газрын гишүүн Зам, тээврийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулахаар хариуцсан нэгж бүрт өгсөн үүрэг 38 үүргийн дундаж үнэлгээ 68.2 хувиар үнэлэгдсэн байна.

3.3. “Гэрээ”-г хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа хагас бүтэн жилээр зорилтод түвшинг тогтоон боловсруулсан ба шалгуур үзүүлтийн дагуу хэрэгжилтийг тайлагнаагүйгээс үнэлгээ хийхэд хүндрэл үүсэж байна.

Дөрөв. Санал, зөвлөмж:

4.1. “Санамж бичиг” түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд “30-50” хувийн хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэн ажиллахад яам, хамтран хэрэгжүүлэгч нийслэлийн нэгж, байгууллагууд анхаарч ажиллах;

4.2. Хэрэгжилт удаашралтай, хангалтгүй байгаа арга хэмжээнүүдийг зорилтод түвшинд хүрч ажиллахад анхаарч, биелэлтийг тодорхой огноо, тоо баримттай, товч бөгөөд нэг арга хэмжээг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнахыг нийт албан хаагчдад зөвлөж байна.

ХШУДАГ